

Та саналаа [uranbileg.m@immigration.gov.mn](mailto:uranbileg.m@immigration.gov.mn) хаягаар өгнө үү.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар сарын -ны өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ХИЛИЙН БООМТООР ОРОХ, ГАРАХ ТУХАЙ

*/Шинэчилсэн найруулга/*

#### **1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэн тус улсын хилийн боомтоор орох, гарах хөдөлгөөнийг зохицуулах, Монгол Улсын иргэний эх орноосоо гарах эрхийг түдгэлзүүлэх үндэслэлийг тогтоох, гадаад улсад зорчих, оршин суух Монгол Улсын иргэний эрх, үүргийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### **2 дугаар зүйл. Монгол Улсын иргэн хилийн боомтоор орох, гарах тухай хууль тогтоомж, олон улсын гэрээ**

2.1.Монгол Улсын иргэн хилийн боомтоор орох, гарах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хилийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### **3 дугаар зүйл. Монгол Улсын иргэн хилийн боомтоор орох, гарах**

3.1.Монгол Улсын иргэн хүчин төгөлдөр паспорт буюу паспортыг орлох баримт бичгээр хилийн боомтоор нэвтэрнэ.

3.2.Монгол Улсын иргэн хилийн боомтоор гарч орохдоо зохих журмын дагуу хилийн хяналтын байгууллагад шалгуулж зөвшөөрсөн тохиолдолд хилийн боомтоор нэвтэрнэ.

3.3.Хилийн боомтоор орох, гарах Монгол Улсын иргэнд дараах зүйлийг хориглоно:

3.3.1.өөрийнхөө болон бусдын талаар хуурамч мэдүүлэг өгөх;

3.3.2.бусдын паспорт буюу паспортыг орлох баримт бичгийг ашиглах, бусдад паспорт буюу паспортыг орлох баримт бичгээ ашиглуулах.

3.4.Дараах тохиолдолд Монгол Улсын иргэнийг тус улсаас гарахыг хориглоно:

3.4.1.хүчин төгөлдөр бус паспорт буюу паспортыг орлох баримт бичигтэй;

3.4.2.хилийн хяналтын байгууллагад паспорт буюу паспортыг орлох баримт бичгээ шалгуулахаас зайлсхийсэн, татгалзсан.

3.5.Хилийн боомтод Монгол Улсын иргэний гарах, орох хөдөлгөөнд хяналт тавих зорилгоор хилийн хяналтын байгууллага Монгол Улсын хилээр нэвтэрч буй иргэдийн гарын хурууны хээ зэрэг биеийн давхцахгүй өгөгдөхүүнийг авах, хадгалах ажиллагааг явуулж болно.

#### **4 дүгээр зүйл. Насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй хүн хилийн боомтоор орох, гарах**

4.1.Насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй хүн гадаадад зорчихдоо зөвхөн эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт явна.

4.2.Эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй хүний хамт гадаадад зорчих боломжгүй тохиолдолд дараах Монгол Улсын иргэнээс бусад иргэнд итгэмжлэл олгон насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй хүнийг гадаадад зорчихыг зөвшөөрч болно:

4.2.1. эрх зүйн бүрэн чадамжгүй;

4.2.2. эцэг, эх байх эрхээ хасуулсан;

4.2.3. иргэний эрх зүйн чадамжаа хязгаарлуулсан.

4.3. Насанд хүрээгүй буюу эрх зүйн чадамжгүй хүнийг итгэмжлэлийн үндсэн дээр Монгол Улсын хилээр авч гарах тохиолдолд хилийн хяналтын байгууллага хяналт тавьж, хүүхэд хамгаалах байгууллагад мэдэгдэнэ.

#### **5 дугаар зүйл.Монгол Улсын иргэний Монгол Улсаас гарах эрхийг түдгэлзүүлэх**

5.1.Монгол Улсын иргэний Монгол улсад орох эрхийг хязгаарлахыг хориглоно.

5.2. Хуульд заасан үндэслэл, журмаар Монгол Улсын иргэний тус улсаас гарах эрхийг хязгаарлах нь түүний гэр бүл, төрөл садны хилийн боомтоор орох, гарах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

5.3. Монгол Улсын иргэний тус улсаас гарах эрхийг дараах үндэслэлээр түдгэлзүүлнэ:

5.3.1.гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан бол уг хэргийг шийдвэрлэх хүртэл;

5.3.2.хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн этгээдэд ялаа бүрэн эдэлж дуусах хүртэл;

5.3.3.иргэний хэрэгт оролцож буйн улмаас шүүгчийн захирамжаар Монгол Улсын хилээр гарахыг түдгэлзүүлсэн;

5.3.4.Монгол Улсын хилээр гарах нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй гэж холбогдох байгууллагаас үзсэн бол;

5.3.5.хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.

5.4.Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан болон албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ял нь шүүхийн шийтгэх тогтоолоор хойшлогдсон, хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээдийн гарах эрхийг түдгэлзүүлэхгүй.

5.5. Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хилээр үл нэвтрүүлэх иргэдийн нэгдсэн бүртгэл хөтлөх бөгөөд Монгол Улсын иргэнийг тус улсаас гарахыг түдгэлзүүлэх талаар ирүүлсэн холбогдох байгууллагын шийдвэрийг үндэслэн хилийн боомтоор нэвтрүүлэхгүй.

5.6.Монгол Улсаас гарах эрхийг түдгэлзүүлсэн Монгол Улсын иргэний мэдээллийг солилцох, хилийн хоригт бүртгэх журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурор, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын ерөнхий шийдвэр гүйцэтгэгч нартай зөвшилцөн батлана.

5.7.Монгол Улсын иргэн хилийн боомтоор орох, гарахтай холбогдсон гомдлоо шүүхэд гаргана.

## **6 дугаар зүйл. Гадаад улсад зорчих, оршин суух Монгол Улсын иргэний эрх, үүрэг**

6.1.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол виз авсан Монгол Улсын иргэн гадаадад улсад зорчих эрхтэй.

6.2.Монгол Улсын иргэн гадаад улсад байхдаа төрийнхөө ивээлд байж, зөрчигдсөн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хуулийн дагуу хамгаалуулах эрхтэй.

6.3.Гадаад улсад байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, гоц халдварт өвчин, онц болон дайны байдал бий болсны улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд аюул учирч болзошгүй нөхцөл буй болсон бол Засгийн газар уг улсад зорчих, оршин суух иргэдэд энэ тухай урьдчилан мэдээлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

6.4.Монгол Улсын иргэнийг гадаад улсад учирч болох байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, гоц халдварт өвчин, онц болон дайны байдлаас сэргийлэх, мэдээлэл өгөх зорилгоор Монгол Улсын иргэний овог нэр, төрсөн он сар өдөр, хүйс, паспортын дугаар, регистрийн дугаар, зорчих улс, хаяг, холбоо барих утас, цахим хаяг, шаардлагатай тохиолдолд холбоо барих хүний мэдээллийг авах цахим бүртгэлийг Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн хөтөлнө.

6.5. Гадаад улсад зорчиж буй Монгол Улсын иргэн энэ хуулийн 6.4-т заасан бүртгэлийг дипломат төлөөлөгчийн болон консулын газарт өөрийн биеэр очиж бүртгэл хийлгэж болно.

## **7 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

Энэ хуулийг 2016 оны дугаар сарын -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

/ТӨСӨЛ/

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ... дугаар  
сарын ... -ний өдөр

Улаанбаатар

ХОТ

### МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ХУВИЙН ХЭРГЭЭР ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1дугаар зүйл.** 1993 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын иргэн хилийн боомтоор орох, гарах тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

**2016 оны ... дугаар  
сарын ... –ны өдөр**

**Улаанбаатар  
хот**

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Зөрчлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.15 дахь хэсгийг “Бусдын паспорт буюу паспортыг орлох баримт бичгийг ашиглах, бусдад паспорт буюу паспортыг орлох баримт бичгээ ашиглуулах, хилийн хяналтын байгууллагад паспорт буюу паспортыг орлох баримт бичгээ шалгуулахаас зайлсхийсэн, татгалзсан бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын иргэн хилийн боомтоор орох, гарах тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## **МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ХИЛИЙН БООМТООР ОРОХ, ГАРАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.6-д “..... хилийн чанадад Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн эрх ашгийг тууштай хамгаалж, иргэд гадаадад зорчих нөхцөлийг улам сайжруулж, эх орноо гадаадад сурталчилан таниулах ажлыг эрчимжүүлэх” зорилт дэвшүүлсэн.

Монгол Улсад гадаадын иргэний хилээр орох, гарах, виз, оршин суух зөвшөөрөл олгох, хяналт тавих, саатуулах, гарахыг түдгэлзүүлэх, албадан гаргах зэрэг харилцааг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар, Монгол Улсын иргэний гадаадад зорчих, цагаачлах, эх орондоо буцаж ирэх, гарахыг түдгэлзүүлэхтэй холбогдсон харилцааг Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулиар, зорчигч, тээврийн хэрэгслийн хилээр шалган нэвтрүүлэх харилцааг Хилийн болон Хилийн боомтын тухай хуулиар тус тус зохицуулж байна.

Бусад улс орны жишгээс харахад тухайн улсын иргэн болон гадаадын иргэн, тээврийн хэрэгслийн хилээр орох, гарах хөдөлгөөн, гадаадын иргэний виз, оршин суух, хяналт шалгалт, саатуулах, гарахыг түдгэлзүүлэх, албадан гаргах зэрэг харилцааг хилээр орох, гарах тухай нэг хуульд багтаан зохицуулсан байдаг. Тухайлбал, БНХАУ-д “БНХАУ-ын хилээр орж гарах тухай хууль” /2013.07.01/, БНСУ-д “Хилээр орох гарах асуудлыг зохицуулах тухай хууль” /1963.03.05/, ОХУ-д “ОХУ-ын хилээр орох, гарах тухай хууль” /1996.08.15/.

1993 онд батлагдсан, хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль нь Монгол Улсын иргэний хилийн боомтоор орох, гарах харилцааг зохицуулсан суурь хууль бөгөөд энэхүү хуулийн зохицуулалт болон нэрийг /Монгол Улсын иргэн хилийн боомтоор орох, гарах тухай/ өөрчлөх нь хуулийн зохицуулах харилцааг цаашид өргөжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх урьдач нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль батлагдсанаас хойш нийт 9 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр 20 гаруй зүйл, заалтад өөрчлөлт орсон хэдий ч хуулийн зүйл, заалтын уялдаа холбоо муу, нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, зохицуулалт нь хуучирсан, зарим шаардлагатай зохицуулалт тусгагдаагүй тул дараах өөрчлөлтийг оруулах нь зүйтэй гэж үзлээ.

1. Монгол Улсын иргэн гагцхүү хувийн хэргээр зорчиход хамааралтай байхаар зохицуулсан хуулийн үйлчлэх хүрээг албан хэргээр зорчиход ч хамааралтай байхаар өөрчлөх.

2.Гадаад улс оронд цагаачлан оршин суух иргэний хүсэлтийг цагаачлан амьдрах улсын эрх бүхий байгууллага хүлээн авч шийдвэрлэдэг. Тухайлбал, Монгол Улсад цагаачлан оршин суух гадаадын иргэний хүсэлт, улс орны дотоод нөхцөл байдал, эдийн засгийн чадамж, цагаачлах хүсэлтэй хүний боловсрол, мэргэжлийг харгалзан гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Монгол Улсад цагаачлан оршин суух зөвшөөрлийг олгож болох талаар Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 29.1-д заасан байдаг.

Харин Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 6 дугаар зүйлд гадаадад цагаачлах Монгол Улсын иргэний хүсэлтийг гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээн авч шийдвэрлэхээр заасан байдаг. Гэвч хуулийн энэхүү зохицуулалт нь хэрэгждэггүй, үүнтэй холбоотой хуулийн дараах заалтууд ч хэрэгждэггүй, зохицуулалт хуучирсан тул хасах саналтай:

-хуулиар тогтоосон төрийн нууцыг мэдэж байгаа болон түүнийг шууд хариуцаж байгаа албан тушаалтан цагаачлах хүсэлт гаргасан бол уг ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн өдрөөс хойш 3 жилийн дотор Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлнэ/5 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэг/;

-гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага цагаачлах хүсэлтийг 30 хоногийн дотор шийдвэрлэнэ /6 дугаар зүйлийн 7 дахь хэсэг/;

-цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн тохиолдолд иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үндэслэл бүхий хариуг бичгээр өгнө./6 дугаар зүйлийн 8 дахь хэсэг/;

-гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гадаадад цагаачлан гарсан Монгол улсын иргэдийн тоо бүртгэлийг нэгтгэн хөтөлнө. /6 дугаар зүйлийн 10 дахь хэсэг/.

-Мөн хуульд заасан дээрх зохицуулалт хэрэгждэггүйтэй холбоотой Захиргааны хариуцлагын тухай хуулийн 28<sup>1</sup> дүгээр зүйл /Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах журам зөрчих/-д заасан торгуулийн шийтгэл ногдуулах хуулийн зохицуулалт хэрэгжих боломжгүй байна.

3.Хуулийн 8 дугаар зүйл /Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлахад олгох баримт бичиг, үндэсний гадаад паспорт/ нь Иргэний бүртгэлийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 126 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспорт олгох,



эзэмших, хадгалах журам”-аар тус тус зохицуулагдаж байгаа тул давхардуулан хуульчилсан, хуулийн зорилтод хамаарахгүй уг зүйл, заалтыг хасах шаардлагатай.

4.Монгол Улсын Үндсэн хуулийн арванзургадугаар зүйлийн 18-д “Монгол Улсын иргэний гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно” гэж заасны дагуу энэхүү хуулиар Монгол Улсын иргэний тус улсаас гарах эрхийг түдгэлзүүлэх үндэслэлийг тогтоож ирсэн.

Монгол Улсын иргэний гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлж байгаа үндэслэлийг дахин авч үзэх шаардлагатай. Тухайлбал, ... 2 буюу түүнээс дээш удаа өөрийн буруугаас гадаад паспортаа гэмтээсэн, хаяж үрэгдүүлсэн этгээдийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр 2 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг түдгэлзүүлж байгаа нь хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх үйл ажиллагаатай хамааралгүй байна.

Мөн Монгол Улсын иргэний гадагш зорчих эрхийг түдгэлзүүлэх эрх бүхий субъект болон түдгэлзүүлэх, хилийн хориг тавих ажиллагааг дараах эрх зүйн актыг үндэслэн шийдвэрлэж байна:

-Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2004 оны 04 дүгээр 02-ны өдрийн 84 дүгээр тушаалаар баталсан “Төлбөрөөс зайлсхийгчдийг эрэн сурвалжлах, Шүүхийн шийдвэрээр биелэлтийг хангах чиглэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн харилцан ажиллах журам”;

-Ерөнхий прокурорын 2015 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар баталсан “Прокурор хилийн хориг тавих, цуцлах журам”;

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2015 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/199 дүгээр тушаалаар баталсан “Шүүхийн шийдвэр биелүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, тоо бүртгэл хөтлөх журам”;

-Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын дарга нарын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/71, А/60, А/51, А/227 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хилийн хориг тавих, цуцлах журам”.

Дээрх журмууд нь хуулиар эрх олгогдоогүй байгаа бөгөөд Монгол Улсын иргэний гарах эрхийг түдгэлзүүлсэн мэдээллийг солилцох, хилийн хоригт бүртгэх журам батлах эрх зүйн зохицуулалтыг оруулах шаардлагатай гэж үзлээ.

5.Хилийн боомтод Монгол Улсын иргэний гарах, орох хөдөлгөөнд хяналт тавих зорилгоор хилийн хяналтын байгууллага Монгол Улсын хилээр нэвтэрч буй

иргэдийн гарын хурууны хээ зэрэг биеийн давхцахгүй өгөгдөхүүнийг авах, хадгалах ажиллагааг явуулж болох эрх зүйн үндэслэлийг оруулах.

Эдгээр өөрчлөлтийн цар хүрээг үзэхэд Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орохоор байгаа тул хуулийн төслийг шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**БАТЛАВ:  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД**

**С.БЯМБАЦОГТ**

**2016 оны ... дугаар сарын ... -ны өдөр**

## **МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ЗОРЧИХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага:**

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.6-д “..... хилийн чанадад Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн эрх ашгийг тууштай хамгаалж, иргэд гадаадад зорчих нөхцөлийг улам сайжруулж, эх орноо гадаадад сурталчилан таниулах ажлыг эрчимжүүлэх” зорилтыг дэвшүүлсэн.

1. Монгол Улсад гадаадын иргэний хилээр орох, гарах, виз, оршин суух зөвшөөрөл олгох, хяналт тавих, саатуулах, гарахыг түдгэлзүүлэх, албадан гаргах зэрэг харилцааг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар, Монгол Улсын иргэний гадаадад зорчих, цагаачлах, эх орондоо буцаж ирэх, гарахыг түдгэлзүүлэхтэй холбогдсон харилцааг Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулиар, зорчигч, тээврийн хэрэгслийн хилээр шалган нэвтрүүлэх харилцааг Хилийн болон Хилийн боомтын тухай хуулиар тус тус зохицуулж байна.

Бусад улс орны жишгээс харахад тухайн улсын иргэн болон гадаадын иргэн, тээврийн хэрэгслийн хилээр орох, гарах хөдөлгөөн, гадаадын иргэний виз, оршин суух, хяналт шалгалт, саатуулах, гарахыг түдгэлзүүлэх, албадан гаргах зэрэг харилцааг нэг хуулиар зохицуулсан байдаг. Тухайлбал, БНХАУ-д “БНХАУ-ын хилээр орж гарах тухай хууль” /2013.07.01/, БНСУ-д “Хилээр орох гарах асуудлыг зохицуулах тухай хууль” /1963.03.05/, ОХУ-д “ОХУ-ын хилээр орох, гарах тухай хууль” /1996.08.15/.

1993 онд батлагдсан, хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль нь Монгол Улсын иргэний хилийн боомтоор орох, гарах харилцааг зохицуулсан суурь хууль бөгөөд энэхүү хуулийн зохицуулалт болон нэрийг /Монгол Улсын иргэн хилийн боомтоор орох, гарах тухай/ өөрчлөх нь хуулийн зохицуулах харилцааг цаашид өргөжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх урьдач нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

2. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль батлагдсанаас хойш нийт 9 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр 20 гаруй зүйл,

заалтад өөрчлөлт орсон хэдий ч хуулийн зүйл, заалтын уялдаа холбоо муу, нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, зохицуулалт нь хуучирсан, зарим шаардлагатай зохицуулалт тусгагдаагүй тул шинэчлэн найруулах нь зүйтэй гэж үзлээ. Тухайлбал, Гадаад улс оронд цагаачлан оршин суух иргэний хүсэлтийг цагаачлан амьдрах улсын эрх бүхий байгууллага хүлээн авч шийдвэрлэдэг.

Харин Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 6 дугаар зүйлд гадаадад цагаачлах Монгол Улсын иргэний хүсэлтийг гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээн авч шийдвэрлэхээр заасан байдаг. Гэвч хуулийн энэхүү зохицуулалт нь хэрэгждэггүй, үүнтэй холбоотой хуулийн холбогдох заалтууд ч хэрэгждэггүй, зохицуулалт хуучирсан тул хасах шаардлага тулгарсан.

3. Хилийн боомтод Монгол Улсын иргэний гарах, орох хөдөлгөөнд хяналт тавих зорилгоор хилийн хяналтын байгууллага Монгол Улсын хилээр нэвтэрч буй иргэдийн гарын хурууны хээ зэрэг биеийн давхцахгүй өгөгдөхүүнийг авах, хадгалах ажиллагааг явуулж болох эрх зүйн үндэслэлийг оруулах шаардлагатай гэж үзлээ.

### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:**

Хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулах бөгөөд хуулийн төсөл нь 7 зүйлтэй байна. Монгол Улсын иргэн хилийн боомтоор орох, гарах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг шинээр тусгана:

1. Хилийн боомтоор орох, гарах Монгол Улсын иргэнд өөрийнхөө болон бусдын талаар хуурамч мэдүүлэг өгөх, бусдын паспорт буюу паспортыг орлох баримт бичгийг ашиглах, бусдад паспорт буюу паспортыг орлох баримт бичгээ ашиглуулахыг хориглох заалтыг шинээр тусгалаа.

2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заагдсан иргэдийн гадаадад зорчих нөхцлийг сайжруулах зорилгоор гагцхүү дараах тохиолдолд Монгол Улсын иргэний хилээр гарах эрхийг түдгэлзүүлэхээр хуулийн төсөлд тусгалаа:

1.гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан бол уг хэргийг шийдвэрлэх хүртэл;

2.хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн этгээдэд ялаа бүрэн эдэлж дуусах хүртэл;

3.иргэний хэрэгт оролцож буйн улмаас шүүгчийн захирамжаар Монгол Улсын хилээр гарахыг түдгэлзүүлсэн;

4.Монгол Улсын хилээр гарах нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй гэж холбогдох байгууллагаас үзсэн бол;

5.хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр. /Тухайлбал, Цэргийн албаны тухай хуулийн 12.11-д Цэрэг татлага явуулах тухай Засгийн газрын тогтоол нийтлэгдсэн өдрөөс эхлэн цэрэг татлагын хугацаа дуусах өдөр хүртэл цэргийн албанд татагдах насны иргэн тухайн нутгийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр гадаадад зорчихыг хориглохоор заасан/

Мөн Монгол Улсын иргэний гарах эрхийг түдгэлзүүлсэн мэдээллийг солилцох, хилийн хоригт бүртгэх журам батлах эрх зүйн зохицуулалтыг оруулсан.

3.Монгол Улсын иргэнийг гадаад улсад учирч болох байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, гоц халдварт өвчин, онц болон дайны байдлаас сэргийлэх зорилгоор Монгол Улсын иргэний овог нэр, төрсөн он сар өдөр, хүйс, паспортын дугаар, регистрийн дугаар, зорчих улс, хаяг, холбоо барих утас, цахим хаяг, шаардлагатай тохиолдолд холбоо барих хүний мэдээллийг авах цахим хаягийг Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн хөтлөхөөр тусгалаа.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:**

1.Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын иргэнийг гадаад улсад учирч болох байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, гоц халдварт өвчин, онц болон дайны байдлаас сэргийлэх зорилгоор тухайн иргэнтэй холбогдох мэдээллийг авах цахим хаягийг эрхлэн хөтлөхөөр тусгасны дагуу програм хангамж зохиоход хөрөнгө шаардагдана.

2. Монгол Улсын иргэний гарах эрхийг түдгэлзүүлсэн мэдээллийг солилцох, хилийн хоригт бүртгэх асуудлыг хуулиар эрх олгогдоогүй 4 журмаар зохицуулж байгаа бөгөөд журам батлах эрх зүйн зохицуулалтыг хуульд оруулснаар хилийн боомтоор гарахыг түдгэлзүүлсэн иргэнийг хилийн хоригт хэрхэн бүртгэх, харилцан мэдээлэл солилцох асуудал нэг журмаар зохицуулагдах эерэг үр дүн бий болно.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаархи санал:**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуультай уялдсан байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Хууль хүчингүй болсонд тооцох тухай,  
Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

-----ooOoo-----